



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/17

Сүхбаатар сум

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "е", 29.2 Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "Хэтөлбөрийн хэрэгжилтийн тухай" 55 дугаар тогтоол, "Сэлэнгэ аймгийн 2020 оны төсөв батлах тухай" 70 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэзэгжүүлж эхэлснээс хойш аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд гарсан өөрчлөлт, түүхийн дурсгалт, аялал жуулчлалын бслон байгалийн үзэсгэлэнт газруудын мэдээллийг багтаасан танилцуулгыг бэлтгэж, нийтийн хүртээл болгосугай.

2. Зардлын төсвийг хавсралтаар баталж, зардалд шаардагдах нийт 5000000 /таван сая/ төгрөгийг "Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардал"-аас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.


3. Зардлын тайланг 2020 оны 3 дугаар сарын 15-ны дотор гаргаж тайлагнахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотроод аудитын хэлтсийн дарга /Д.Лувсандагва/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Аймгийн Засаг даргын 2020 оны
02 дугаар сарын 03-ны өдрийн
А/12 тоот захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Гаргах зардлын нэр	Сэтгүүлийн нэр	Нэг бүрийн үнэ	Тоо, ширхэг	Нийт
1	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаар 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтын 1.10	Танилцуулга	5000	1000	5.000.000
Дүн					5.000.000

Төсөв гаргасан:

Д.Хишигбат
/АЗДТГ-ын ХШҮДАХ-ийн/
ахлах мэргэжилтэн

Төсөв хянасан:

З.Загдсүрэн
/АЗДТГ-ын нягтлан бодогч/